

ХАТАН СОНГОХ УЛАМЖЛАЛ ХИЙГЭЭД ХҮМҮҮНИЙ ШИНЖИЙН НЭГЭН СУДРЫН ТУХАЙД

Г. Нандинбилэг*

Сайхан муухайн тухай монгол хүний үзэл төсөөллийн үүсэл гарал ба ерөнхий зарчим нь гэгээ харанхуй, гэрэл сүүдрийн тухайт /гэгээ, гэрэл-сайхан, харанхуй, сүүдэр-муухай гэх мэт/ байгалийн шүтлэг, гүн ухаантайгаа ихээхэн учир холбогдолтой бөгөөд эмэгтэй хүний үзэсгэлэн чанар нь нүүр царайн өнгө гэрээ хийгээд сэцэн мэргэн ухаан, зөнч авьяас билигтээ буй хэмээн үздэг. Одоогоос арван жилийн өмнө бид монголчуудын язгуурын гоо сайхны үзэл ойлголт гэж чухам ямар зүйл байгааг тодруулах зорилгоор үүсэл гарлын хувьд эртний домог зүй, дом шившлэг, бөө мөргөлтэйгээ нягт холбоотой, монгол угсаатны өөрсдийнх нь оюун санааны /зээлдмэл ормол бус/ туурвил болох баатарлаг туульст сайхны тухай асуудал хэрхэн өвөрмөцөөр төсөөлөгдөж буйг судлан нэг сэдэвт зохиол бичиж байсан билээ.

Харин энэ удаад баатарлаг туульсын уламжлалын удаагаар хатдын гоо сайхны үзэл хэрхэн өөрчлөгдсөн хийгээд уламжилсныг баримжаалах зорилгоор хүний шинжийн сударт тэмдэглэсэн эмэгтэй хүний сайн сайхан шинжийг хатан сонгох ёсонд түшиглэн авч үзэж байна. Хорь гаруй жилийн өмнө манай улс анх удаа сайхан бүсгүй шалгаруулах тэмцээн зохиож байх үес хувьсгалаас өмнө монголд “Ноёны шүүлэг” гэж сонин ёс байсан тухай миний эмэг эх Лханаагийн Сосор¹ дам хуучилж билээ. Ноёны шүүлэг гэдэг нь угсаа гаралтай том ноёд хатан авахдаа хошууны охид бүсгүйчүүдээс залуу сайхан охидыг сонгон авчраад, өнгө зүс, бие хаа, авьяас билиг, эрдэм ухаанаар нь уралдуудах замаар хатан сонгон шалгаруулж авах ёс ажээ. Ноёны шүүлгийн болзолд эмэгтэйчүүдийн царай зүс мэдээж чухал зүйл боловч хамгийн гол нь эрүүл саруул нуган үр төрүүлэх чадвар хийгээд ааш зан эелдэг, арга ухаан сэцэн, эдийн чанар хийгээд идээний амт таних шинж, оёдол үйлд гарын болоод нүдний уртай эсэх зэргийг шалгадаг байжээ. Эдгээрээс ойлгож ухаарахад хэцүү байсан нэг зүйл бол шүүлэгт тунасан охидын хувцсыг тайлж, оронд оруулаад, лам багш болон их гэрийн хатан зэрэг улс хучлага дотуур нь гараа оруулж, тэмтэрч шинждэг байсан тухай мэдээ юм. Хэдийгээр энэ хууч нь хэн гэж ноёны шүүлэг хэдийд болсон зэрэг бодтой нэр баримтыг товтой өгч чадахгүй байгаа ч ийм ёс байсныг мэдээлээд зогсохгүй хатан шинжих ёсны талаар сонирхолтой зүйлийг мэдээлж байгаа юм.

* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор, дэд профессор

¹ Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын уугуул, Хариад овогтой, Лханаагийн Сосор, 1918 онд төрсөн, морь жилтэй, эмэгтэй. 1990-ээд оны үес 70 гаруй настайдаа хуучилж байсныг хожим сэргээн санаж бичив.

Тус хуучид өгүүлж буй хатан шинжих ёстой төсөөтэй өөр нэгэн мэдээг хожим бид ахмад зохиолч Ч.Баасанжав² гуайгаас сонссон юм. Хүрээ хөдөөгийн хатад ноёдын талаар аман хууч их сонсож цуглуулсан тэрээр сонссон дуулсанаасаа үндэслээд *“манай монголчууд хатан болох хүнийг багаас нь бэлтгэдэг байж, хатан сонгоно гэдэг нарийн шинжээ шалгууртай ажил байж”* гээд *“хатан болгох хүүхнийг хатан болгож авахаасаа өмнө туршилагатай эмэгтэйчүүдтэй хамт зэрэгцүүлж хонуулаад амьсгалыг чагнан шинждэг байсан байна”* гэж дам мэдээлсэн юм.

Энэ бүхнийг өгүүлэхийн учир бол 2010 оны 8-р сард бид орон нутагт хээрийн шинжилгээгээр ажиллаж байгаад Хөвсгөл аймгийн Галт сумын нутаг буюу Идэрийн ар биед зусч байсан Гомбын Мятаг³ гэж хүнээс *“Манзуирийн гэгээний айлдсан зарлиг хүмүүний сайн муу хоёрыг шинжлэн танигсан судар оривой”* хэмээх нэртэй гар бичмэл судрыг олж үзсэн юм. Мятаг гуай бол өөрийн сонирголоор ном судар, соёлын өвийг цуглуулагч нэгэн бөгөөд тус судрыг ноёны шүүлгэнд хэрэглэж байсан судар байх магадгүй гээд Галт сумын Зүрх багийн орчмоос нутгийн хүнээс авсанаа бидэнд мэдээлсэн юм. Зүрх багийн нутаг бол хуучин Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны гол багийн нутаг ба Зүрх уулынхаа нэрээр Зүрхийн тайж нар гэж нэршсэн миний авга нарын нутаг билээ.

Энэ гар бичмэл судар нь монгол бичгээр ар өвөргүй бичсэн 9 хуудас судар бөгөөд эхний хэсэгт сайн муу хүний ерөнхий шинжийг өгүүлээд 6-р хуудасны *“Б”* талаас эхлэн эмэгтэй хүнийг шинжих талаар өгүүлжээ. Судар эхлэхдээ *“Ум сувашиди шадам. Хутагт манзуири дор мөргөмү. Данжуурын доторх хүмүүний шинжэ жамцу бээр үзүүлсэн тэргүүтэн гэсэн дандарсын таалал лугаа зохилдуулсан эр хүн ба эм хүмүүнийг шинжлэхүйн аргыг товчлон хурааж бичсүгэй”* гэх эхлэх бөгөөд судрын төгсгөлд *“Хүмүүний шинжэ төгсвэй. Түгээмэл дэлхий дахин дор агч хүмүүний даяар бээр төгс лагшинт эрдэнэ мэтийн бодгальс болоод түргэн тод мөр, нууц тарнийн хөлгөн дор орж, түгээмлийн эзэн Очирдарын хутгийг түргэн олох болтугай хэмээсэн үүнийг Энэтхэгийн орны арш Жамцу бээр үзүүлсэн ба Төвдийн орны Сүмбэ хамба хийгээд Лондол лам, Хэлүвсан нарын айлдагсанаас товчлон хурааж, монголчлон цорж гүнбилигт нэр хадгалсан өчүүхэн Лувсансамдандагва бээр эвсүүлэн бичсэн болой. Өлзий хутаг ориших болтугай”* хэмээн бичжээ.

Сударт өгүүлсэн шинжээ нь *“Ер хүмүүн гүйцэд хэмжээ төгсвөөс сайн бөлгөө. Тэр ч өөрийн хуруугаар хэмжвээс нүүр дор хуруу арван дөрөв буюу эсвээс арван хоёр буй бөгөөд түүний дотор эрүүний үзүүрээс хамар хүртэл 4, хамар нь 4, хацар нь 5, шанаа нь 4, чихний өргөн нь 2, урт нь 4, чихний нүх 1 буюу хагас, хөмсөг 4, өргөн нь 2, шинийн сар мэт, нүдний урт нь 4, өргөн нь 2, хамрын үзүүр өргөн нь 2, дээд доод уруул өргөн нь 1, 1, эрүүний үзүүр өргөн нь 2...”* гэхчлэн хүний өөрийн гарын хуруугаар хэмжин зохист харьцааг гаргах ёс тод харагдахаас гадна

“...хүйс нь гүн бөгөөд төгрөг, баруун уйлгалсан нь сайн... бэлхүүс нарийн, хүйс гүн, хүйсний доорд хөндлөн зураг хоёр буюу гурав буй”. Гуя нь тэгш дүүрэн бөгөөс сайн гэхчлэн Гаалидаасын “Үүлэн зардас”-т гардаг шиг “хүйс гүн, гуя зузаан, уруул бямба

² Архангай аймгийн Тариат сумын уугуул, Тайжууд овогтой Ч.Баасанжав, 1938 онд төрсөн, бар жилтэй, эрэгтэй. 2010 оны намар МУИС-ийн Утга зохиолын тэнхимд тэмдэглэн авав.

³ Хөвсгөл аймгийн Галт сумын уугуул Гомбын Мятаг, 1958 онд төрсөн, нохой жилтэй. 2010 оны 8 сарын 15-нд тэмдэглэн авав.

улаан...” гэхчлэн энэтхэгийн гоо сайхны мэдлэг хийгээд “уртлаг нүд” зэрэг нь бурхдын дүртэй холбоотой мэдлэг нэгэн үе давхаргаар ажиглагдах боловч

“.. манлайн зураг тэгш, нүүр хацар дэлгэр, үзэсгэлэнтэй, хөмсөг хар, шүд цагаан тэгш, нүд уужим, уруул улаан тэгш, зураг үзэсгэлэнтэй, .. хацар урт бөөрөнхий зөөлөн эелдэг, зураг нь тод сайн зурагтай..” гэхчлэн туульсын авхай дагинас хийгээд монгол хатдын дүр төрх нэгэн үе тодорч, улмаар “... чихний гэдэс урт бөгөөс сайн, дээд уруул улаан тэгш үзэсгэлэнтэй бөгөөс сайн ам их боловчиг уруулын өнгө улаан бөгөөс баялаг болмой... Хурууны өндөг нь баруун эргэсэн зурагтай нь олон хөвгүүнийг олох, зүүн эргэсэн нь олон охинтой болмой” гэхчлэн ардын мэдлэг нэгэн үе ажиглагдахын зэрэгцээ “толгой нь шүүр /сихүр/ мэт төгрөг, үс нь зөөлөн, ширүүн бүдүүн нарийн нь тэгш, шаравтар үстэй болбоос баян болмуй. Магнай нь уужим болоод тэгш хоёр атирал буй бөгөөс 60, тэрчлэн 4 бөгөөс 70, 5 бөгөөс 80, 7 бөгөөс 100 насалмой. Дээш босоо нэгэн зурагтай буюу гурван үзүүртэй бөгөөс сайн, эрдэмгүй бөгөөс нас ахар...Нүд гурвалжин бөгөөс ухаан сайтай. Галууны нүд адил бөгөөс эд төгөлдөр, гөрөөсний нүд мэт бөгөөс ноён болох, шаравтар бөгөөс эрх баялгийг олмой...Гарын өнгө шаравтар бөгөөс эд ба ухааны эзэн болмой...” гэхчлэн монголчуудын нас буяны тухай уламжлалт ойлголт зэрэгцэн орж ирэх нь ажиглагдаж байна.

Монгол хатдыг нүдээр харж байсан гадаадын жуулчдын тэмдэглэлээс үзвэл, сайхан гэдгийг бүхий л үзэл онолд нэгэн мөр тодорхойлсон зүйл байхгүйн дээр дэлхий дэхиний улс үндэстний аман уламжлал болгонд өөр өөр үзэл төсөөлөл илэрхийлж байдаг нь аман зохиолын бүтээл, тэр дундаа туульс үлэмж үндэсний өвөрмөц шинж чанартай заримдаа бүр нутаг нутгийн шинжтэй байдагт оршино. Энд нэгэн сонирхолтой жишээг иш татахад XIII зууны үед монгол газар жуулчилсан Францискан санваартан Гийом де Рубрук Францын ван IX Людовикийн зараалаар 1253 онд Монгол газар морилон ирэхдээ Батхааны хүү Сартагийн хатадтай анх тааралдаад “эмэгтэйчүүд нь хэн алин үгүй бүр хэтэрхий юүлхгэр тарган байдаг, хамар нь хичнээн мялтгар байх тусам төчнөөн хөөрхөн санагдана гэлцдэг, тэгээд царай дээрээ муухай юм түрхээж өнгө зүсээ бүрмөсөн хувируулчихсан явцгааж байдаг” /Плано Карпини, Гийом /Вильям /Рубрук, Монголд жуулчилсан тэмдэглэл, Хөх хот, 1983, 292 / гэхчлэн бараг ой гутсан аястай зүйлийг бичиж үлдээжээ. Энэ нь нэгэн цаг үеийн францчууд, монголчуудын бүсгүй хүний гоо сайхны тухай үзэлд ямар их зөрөө байсныг харуулж байна. Гэтэл энэ нь бидний мэдээжээр нүд дүүрэн тарган цатгалан, хааны эрхэмсэг хатад сүүлний өөхөнд багсарсан хөөн энгэсэг түрхчихээд явж байсан хэрэг. Малтгар намхан хамар нь ч франц хүмүүний гоо сайхны үзэлд сөрөг үнэлэмж болж байсан нь ойлгомжтой. Бидэнд дэлхийн хоёрхон угсаатны гоо сайхны нэгэн цагийн үнэлэмжийн тухайд л өгүүлэхэд ийм байна.

Монгол хатны гоо сайхны тухай нүдээр үзсэн монгол хүний үг гэвэл, манай өвгөн зохиолч, сэтгүүлч Г.Навааннамжил гуай “Өвгөн бичээчийн үгүүлэл” /ШУХ, ред Х.Пэрлээ, УБ., 1956/ хэмээх намтар дурсамжсдаа Түшээт хан аймгийн чуулганы даргын жасааны тухай бичихдээ /аймгийн чуулганы дарга нь бээс Дондовжалбаа гэгч ноён байж./ Даа ноёны хатан Цогтдарь хатныг нүдээр харснаа дүрслэн бичсэн байдаг. Түүний өгүүлэхээр “...хатан Цогтдарь гэгч хорь илүү настай, махлаг цав цагаан царайтай, нүд нь цагаан хараар ялгарч үнэхээр лавай дээр лүнтэн шигтгэсэн мэт бөмбөрөн тормолзон харах нь тун ч хөөрхөн байдалтай. Хөмсөг нь зуравгар хар, хамар шударга, ам бяцхан, хоёр улаан уруулын завсраар дун цагаан шүд яралзана. Хоёр хацарт дүүрэн, бяцхан энгэсэг түрхээж, цав цагаан царайд оо түрхсэнгүй атал аяндаа

улбалзана. Инэвэлзээж баясч, ийш тийш харахад урьд үзээгүй залуус ухаан алдаж мунхармаар. Арван хуруу нь нарийхан махлаг бөгөөд алтан бөгжийг хосолж зүүжээ. Толгойн дор алт, шүр, сувд, тана, шүр эрдэнийн чулуу шигтгэсэн мөнгөн чимэг зүүж, хоёр талын далбаа үсийг өргөн гэгч хавтгайлан, мөн олон үе алтан шармал мөнгөн хавчааруудаар хавчжээ... гэхчлэн өмссөн хувцас бүрийг тоочоод "Ааль зан нь төв номхон бөгөөд алхах гишгэх бүр агар зандангийн үнэр анхилж, дөрвөлжин магнаг түшлэг дээр сууж, дөрвөн зүгийн хүмүүсийг ажиглан байх нь тун ч гуа сайхан эмэгтэйн дүрс илэрнэ" /Г.Навааннамжил, 1956, 146-147/ гэж бичжээ. Энэ бол амьд хатныг харсан хүнийүг бөгөөд туульсын дүрслэлтэй нийлэхийн зэрэгцээ мөн хүний шинжийн сударт өгүүлэх сайн шинжтэй ам авалцан тохирч байна.

Сударт цааш өгүүлэхдээ "Бодтой шинжлэхийн арга нь 5 орон урт, бас 5 нарийн, 4 нь ахар, 6 нь өндөр, 7 улаан, 3 гүн, 3 уужим болбоос сайн бөлгөө. 5 урт хэмээвээс гар, нүд, хамар, өвчүү, өвдөг. 5 нарийн нь үс, хуруу, үжис, нэрс, шүд болой. 4 ахар нь хоолой, хөлийн өлмий, хянга шилбэ, эрүү болой. 6 өндөр нь манлай, хамар, өвдөг, өвчүү, суга, хавирга болой. 7 улаан нь тагнай, хэл, нүдний хязгаар, уруул, хумс, хөл гарын алга болой. Гурван гүн нь эгиш, сэтгэл, хүйс, гурван уужим нь толгой манлай, өвчүү болой. Эдгээр бүрдвээс маш сайн" гээд сайн мууг тус тус шинжин нарийвчилжээ. Үүнийг дэлгэрэнгүй танилцуулбал:

"6Б. ... Бас бус эм хүмүүний муу шинж нь хураангуйлан бичвээс: бие бүдүүн, чих дэлбэн, үс нь шар буюу улаан, сэрэвгэр, гар нимгэн, манлайн зураг тэгшгүй, нүдний сар мий дугаа адил, хөдөлгөөнтэй бөгөөд эр хүний суусан газар явах, үзэхүй дор баясах, хамар нь очүүхэн нимгэн, хянга нь гулжигар, нэн урт, хацар нь хатингар, нүүр дор гүвдрүү ба хөлс элбэг, шүд саруй, дорсгой.

7А. Уруул зузаан хар, тагнай шараатар, хэл нь нимгэн буюу нэн зузаан, хар буюу цайвар, хоолой нь хатингар, судал олонтой, биед хар тэмдэг буй бөгөөд бөхтөр, гар нь үс олон, их бага зураг тэгшгүй долоовор хуруу их, хумс хагархай буюу өөтэй, өвчүү нимгэн хөх, саруй, хатингар, гар нь очүүхэн хатингар, судал олонтой, хүйсний дунд товгор, бэлхүүс бүдүүн, бэлиг ба хошинго нь хатингар хөндий байдалтай, гуя дор хоёр зураг буй. өлмийний үс товгор, хөлийн ул нэн зузаан буюу нэн нимгэн, хөлийн хуруу газарт үл хүрэх, чоно ба тахианы явдалтай эдгээр муу хэмээн номловой. Бас бус эм хүмүүний таван гэм нь насад эр бусдыг сэтгэх, эм бусдад атаархах,

7Б. муу санаатай, харам ихтэй, зохисгүй үйлийг үйлдэхүй дор баясах энэ 5 болой. Бас биеийн 8 гэм нь эсэр-үн нүхгүй, хүзүү нь ахар, хөх их, мах сул, дууны аялгуу бөхт, бараа очүүхэн, нөхрөө айлгах тогторлогч эдгээр олон буй. Бас сэтгэлийн 8 гэм нь нисванис олон, тачаалд шунах, оюун батгүй, идэхүй дор бэрх, арга башир ихтэй, оюун мохдог, билиг цалгар, самбаа сул эдгээр болой. Бас мөн чанараар дайсагнагч эрлэг мэт хийгээд шивэгчнээ ноёлогч хатагтай мэт ба адлан шамшигч хулгайч мэт эдгээр гурвыг насад асар тэвч хэмээн номложээ. Сайн шинж нь үс зөөлөн, гарын хэмжээ тэгш, хоолой бүдүүн, манлайн зураг

8А. Тэгш, нүүр хацар дэлгэр, үзэсгэлэнтэй, хөмсөг хар, шүд цагаан тэгш, нүд уужим, зүүн өндөр уруул улаан тэгш, зураг үзэсгэлэнтэй, хамар өндөр, нүдний хязгаар улаан, хэл улаан урт, эгиш нь нарийн эелдэг яруу, хацар урт бөөрөнхий зөөлөн эелдэг, зураг нь тод сайн зурагтай, гарын хурууг зэрэгцүүлж босговоос завсаргүй. Аарцаг дэлгэр бөгөөд зузаан, нууц орон эелдэг зузаан, үс очүүхэн бөгөөд зөөлөн, бэлхүүс нарийн, хүйс гүн, хүйсний доорд хөндлөн зураг хоёр буюу гурав буй. суганы нүхний шар

үс өчүүхэн бөгөөд хох нь өндөр чийрэг шударгуу бөгөөд тэгш цагаан, гуяны дээд бие дэлгэр бөөрөнхий, хөлс ба үнэр, идэш нь бага. Үс бие онгө сайтай, хөл гарын хуруу

8Б. урт завсаргүй, хумс улаан бөөрөнхий, газар дэлхий хөдөлгөх мэт галууны явдлаар баруун эргээж няцах, нүд бие үсгүй, биеийн нарийн нь сайн, бас лянхуа буюу андны 6 шинж нь яст мэлхийн ар мэт өндөр их зааны далан мэт чийрэг, үсгүй, мах дэлгэр, гүн уужим цагаан буюу улаан эдгээр сайн болой.” хэмээгээд “...Сайн бүхэн бүрдэх бэрх, хагас шинж төгсөвчиг өлзийтэй болой хэмээн номловой. Эм хүмүүний 8 эрдэм нь нөхрөө үгүйд боловчиг тачаангуй эрхэд үл одох, эр бусдыг үл сэтгэх, эхнэр бусдад атаархал үгүй, дэмий чалчаа үгүй, үнэн дор өгүүлэх, санаа зохилдох ба буруу үзэлгүй, хөвгүүн заяа ихтэй, энэ найм болой” гэжээ. Судрын шинжээнээс үзэхэд монгол эмэгтэй хүний бие бодын шинжийг хөрш зэргэлдээ харь орны хүмүүсийн бие бодын шинжтэй харгуулан үзээд, үндэстний онцлог шинжээ бүрэн хадгалж байхыг эрхэм сайн хэмээн үзсэн нь тодорхой ажиглагдахын зэрэгцээ эхнэр хүний ариун журмыг гойд анхаарсан нь харагдана.

Монголчууд охид хүүхдээ ариун журамт, ухаант гэргийн ёсонд багаас нь хүмүүжүүлж бэлтгэдэг уламжлалтай байсныг Өэлүн эх, Мандухай хатнаар тэргүүлэн бэлхнээ өгүүлж болох ч арай ойрын түүхээс эш татан сөхвөл, Богд гэгээн ч эмэгтэй хүний гадаад гоёл үзэмжээс илүү ухаан эрдэм, ариун журамт ёсыг эрхэмлэдэг байсан нь Улсын төв номын санд /4656/96/ хадгалагдаж буй Богдын Алтан зарлигаас харагдана. Тэрээр

“...Эхнэр хүүхэд бөгөөс хоёр ташаандаа

Элдэв зүйлийн юмыг хангир янгир зүүгээд

Толгой хүзүүндээ алт мөнгө шүр сувдыг ярайтал чимээд

Хацар уруулаа нарийн будгаар ширдээж

Хайр тачаангуйг юунд эрхэмлэнэ та.

Хүчит эрлэгийн ирэхийн цагт ямар тус болох вэ

Та нарын үүнийг адилтгавал

Хаврын цагт ярайсан навч цэцэг

Намрын цагт нэг л шөнийн хяруунаар

Хөлдөөж унах мэт биш үү...” /Богдын лүндэн. (2002), 154, Улаанбаатар/

Монгол төрийн ёсонд журамт сайн эхнэр бол төрийн хүнд онцгой сайн ач холбогдолтой нэг хүчин зүйл гэж үзэж байсны нэг баримт бол Богд журамт хатдыг зохих ёсоор үнэлж байсан болохыг Богдоос журамт гэргийд олгосон өргөмжлөл, халамж зэрэг нь батална. Журамт хатныг халамжилсан жишээ гэвэл, Монгол улсын түүхийн төв архивт /ФА-2. Д 1. хн 14/ хадгалагдаж буй шашин төрийг хослон баригч, нарангэрэлт, түмэн наст Богд эзэн хааны зарлигт “Урьд тушаалын засагт хан Сономравдан агсны хатан Цэсүрэнгийн дутах хэрэглэлийн толгойн хэрэглэл дөрөв, арын гуу хоёр, сүйх хоёрыг малгай зэрэг аар саар хувцас зэргийн хамтаар хурднаа зэхэж, хөөн гаргуулан олгуулагтун. Олноо өргөгдсөний 4 он, гуравдугаар сарын 25” /Богдын лүндэн,эмхт Богд судлаач Н.Дугарсүрэн, УБ., 2002, 288/ гэжээ. Мөн “Дотоод яамны бүгд захиран шийтгэгчийн бичиг Тамга дарсан өргөмжлөл бичиг хадгалуулсны учир олноо өргөгдсөний 4 он хаврын тэргүүн сарын 25-нд Дээд зарлиг болгосон нь : шашин төрийг хослон баригч, наран гэрэлт, түмэн наст Богд эзэн хааны зарлиг: Түшээт хан аймгийн сайд, чуулганы дарга, дархан засаг, хошой чин ван, төрийн жүн ван Ширнэндамдингийн авааль, төрийн хатан шарнууд овогтой Сундуй бол анх хадамласнаас нааш сайнаар үйлчлэн дотнолж гэргийн ёсыг болгоомжлон, цэвэр

ичимтгийгээр хэлхээ журмыг сахиж явсан тул чамд өргөмжлөл олгов. Чи бээр хишигийг сүслэн болгоомжилж явагтун. Бүү олгорхон бардамнаж, журам хэлхээг өдөөрхөхөд хүргүүлтүгэй хэмээн сануулж, өргөмжлөл олгуулагтун гэснийг хичээнгүйлэн дагаж, манай Дотоод яамнаа тамга дарсан өргөмжлал бичигийтгэн гаргаж, шадар сайд, эрдэнэ жсонон ван, төрийн жүн ван Ширнэндамдингийн авааль, төрийн хатан Сундуйд гардуулав Олноо өргөгдсөний 4 он, хоёрдугаар сарын 3” /Богдын лүндэн, УБ., 2002,287/ гэж зарлиг болгож, журамт хатныг өргөмжилж, халамжилж байжээ. Эдгээр нь Дондогдулам хатанд Эрх цагаан Дар эх, Улсын эх дагина өргөмжлөхийн нэгэн гол үндэс нь үнэн журамт ухаант хатан байсныг батлах төдийгүй энэ дашрамд таамаглахад Дондогдулам хатан бол богдтой зүгээр нэг тохиолдлоор таарсан нэгэн биш, гэрийн хүмүүжлээрээ хатны эрдэмд багаас бэлтгэгдэн боловсорч, өөрийн эрдэм чадал, хүмүүжил боловсролоор шинж төгсөн шалгарч, монголын төрийн бодлогоор богдод ойр шадарлаж, түвд богдыг монгол ухаанд сургасан ухаант хатан байжээ гэж хэлж болно.

Энэ бүхнээс дүгнэж хэлэхэд:

1. Монгол хатдын гадаад үзэмжийн хувьд сударт өгүүлсэн шинжүүдийг ерөнхийд нь ажиглан хэлбэл, бурхны хөрөг дүрийн доор орж ирсэн энэтхэг түвдийн гоо сайхны тааламж таашаал, нууц тарнийн ёсны зарим нэг зүйлсийг эс тооцвол монгол хүний бие эрхтний гол гол онцлогийг тусган номлож, харь үндэстний шинж өөрийн яс цусанд орж ирэхээс болгоомжлон хамгаалсан “төрийн бодлого”-ын нэг хэсэг гэмээр онцлог шинж бүхий судар байна.
2. Монголчууд хаан төрийн хатан эрдэнээ холын бодолтой бэлтгэж, нарийн шүүн сонгож суулгаж байсан ба ялангуяа ариун журам, эрдэм ухааныг эрхэмлэн сонгож байсан нь хууч яриа хийгээд судрын сурвалжаар батлагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Сурвалжлан цуглуулж, эмхтгэн хэвлүүлсэн Г.Жамсранжав, Н.Дугарсүрэн. (2002) *Богдын лүндэн. “Хаадын номын сан”*. Улаанбаатар.,
2. Болдбаатар Ж. (2003) *Монгол улсын хэмжээт цаазат Богд хаан (1921-1924)*. Мөн зохиогчийн “Түүх зулсан он жилүүдийн ойллого” номд, Хоёрдугаар боть, х- 234-239. Улаанбаатар.,
3. Гүнзээ Ч. (2010 оны 11-р сарын 07, Ням гариг) *Монголын Буддын шашинт эмэгтэйчүүдийн эрт эдүгээ*. buddha.mn/index.php
4. Дамдинсүрэн Ц. (1959) “*Өвгөн Жамбалын яриа*”. Улаанбаатар.,
5. Наваанамжил Г. (1956) “*Өвгөн бичээчийн үгүүлэл*”. ШУХ, Улаанбаатар.,
6. Нандинбилиг Г. (2001) “*Монгол баатарлаг туульс дахь сайхны тухай үзэл*”. Улаанбаатар.,
7. Хүрэлбаатар Л., Жамсранжав Г. (2010) *Монголын найман Богд: Намтар цадиг, Сургаал айлдвар, Бошиг лүндэн*. Монголын утга зохиол судлалын төв, 186 т.х. Улаанбаатар.,

SUMMARY

Analyzing the qualities and characteristics of Mongol queens mentioned in sutras, the main peculiarities of Mongol woman body parts have been reflected in them despite the beauty of Indian-Tibetan female deities that have come through the Buddhist icons. The sutra is a kind of ‘state policy’ that avoids the characteristics of foreigners and penetrates into Mongol’s generation and kinship.

Kings of Mongol state had chosen their queens by such criteria as purity, wisdom and knowledge, proven by an oral and written source.